

МОНГОЛ, БРИТАНИЙ ХАРИЛЦААНД ХОЛБОГДОХ АРХИВЫН БАРИМТЫН ТОЙМООС

Д. Золбоо

Дипломат харилцаа тогтоогоод 40 жил болсон манай хоёр орны харилцааны түүхэнд холбогдолтой архивын баримт Монгол Улсын Үндэсний Төв Архив, МАХН-ын архив, Гадаад хэргийн яамны Гадаад харилцааны төрөлжсөн архивт голлон хадгалагдаж байдаг талаар үүний өмнөх өгүүлэлдээ товч дурьдсан билээ.

Эдгээрийн дотроос Гадаад харилцааны төрөлжсөн архив нь мэргэжлийн байгууллагын хувьд манай орны гадаад харилцааны түүхийн холбогдолтой баялаг баримт бичиг бүхий сан хөмрөгийг хадгалж байна. Уг архивт Британий холбогдолтой 200 гаруй хадгаламжийн нэгж баримт бичгийг 28-р хөмрөг болгон төрөлжүүлэн хадгалдаг ажээ. Тэдгээр баримтыг цаг хугацааны хувьд харилцаа тогтоохоос өмнөх үеийн буюу ХХ зууны эхнээс 1963 он, харилцаа тогтоосны дараах үе 1963-1989 он, ардчиллын үе буюу 1990 оноос хойших хэсэг гэж 3 хэсэг болгон хуваан үзэж болох юм. Агуулгын хувьд улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбар болон хувь хүмүүсийн хоорондын харилцааны холбогдолтой баримт бичиг, цөөн тооны гэрэл зургаас бүрддэг ажээ. Мөн тухайн үеийн гадаад харилцаанд голлох үүргийг гүйцэтгэж байсан МАХН-аас Британий Коммунист намтай харилцаж байсан харилцаа, Британи дахь Монгол судлалын байдал зэрэг олон сонирхолтой мэдээллийг эндээс үзэж болох байна.

Энэ удаад урьд өмнө эрдэм шинжилгээний эргэлтэд орж байгаагүй зарим нэгэн сонирхолтой баримтаас товч танилцуулья. Энэхүү хөмрөгийн хамгийн эртний баримт нь “Бидерманы пүүс” буюу “The Fur and Wool” (D.Bidermann) limited компаний 1921 оны 10 сарын үед бичсэн нугалбар бичиг юм. Уг пүүс нь Британий Лондон хотод төвтэй бөгөөд манай орны Нийслэл хүрээ, Улиастай болон Хятадын хойд хэсгийн Харбин, Хайлаар, Хаалган зэрэг томоохон хот суурин газар салбар нэгжүүдтэй бөгөөд ангийн үс, малын ноос, ноолуурын арилжаа эрхэлдэг худалдааны компани байсан бололтой. Гэвч Нийслэл хүрээн дэх салбарт нь голчлон монголд амьдардаг орос хүмүүс ажилладаг байжээ. Уг хөмрөгийн баримтын дотор уг пүүсийн төлөөлөгч Василий Петрович Запаринаас худалдааны ажил эрхэлж явуулах болсноо мэдэгдэж Гадаад яаманд ирүүлсэн бичиг болон эрхийн бичиг, Цагаантаны үед хураагдсан эд барааг буцааж олгоно уу гэсэн бичиг, Алтанбулагт түрээсэлж авсан газрын тухай, ноос, тарваганы арьс худалдах асуудлаар Харилцан туслалцах хоршооноос Бидерман пүүст явуулсан бичиг, цуглуулсан тарваганы арьсаа Жанчхүү рүү явуулах зөвшөөрөл хүссэн бичиг¹ зэрэг

олон сонирхолтой баримт хадгалагдаж байна. Мөн улсын санд багагүй хэмжээний төгрөгийг татварын журмаар хураалгаж байсан талаарх баримт ч цөөнгүй байна.

Тухайн үед гадны хөрөнгө оруулалттай худалдааны олон байгууллага байсны дотор Британий компаниуд цөөнгүй хувийг эзэлж байсан бололтой. Жишээ нь, Засгийн газрын Сангийн явдлын яамнаас Ардын засгийн газрын Гадаад явдлын яаманд илгээсэн нэгэн бичигт "... Хуудсаар илгээхийн учир, Баялгийг бадруулах хэлтсийн өргөсөн нь, мөнөөхөн Инглиш (English гэдэг үгийн дуудлагыг тэмдэглэсэн бололтой) зэрэг 2 улсын хоршооны төлөөлөгч орос Михайл Лушниковоос Сайн ноён хан аймгийн орчим нутагт алт ба зэс, төмөр зэргийн олон зүйл уурхай нээх зэргийг хугацаагаар олгоно уу хэмээн...² " бичсэн байх ажээ.

Тухайн үед хоёр орны хооронд албан ёсны харилцаа тогтоогүй байсан учраас зарим нэгэн асуудал гардаг байсан бололтой. Энэ талаарх нэгэн баримт гэвэл, Монгол Улсын 19 он буюу 1929 оны 4 сарын 9-ний өдөр Засгийн газрын эрхлэх товчооны гишүүд хуралдсан 45-р хурлын тогтоол, 9-р зүйл Гадаад яам, Дотоодыг хамгаалах газраас тус улсад худалдаалан суугаа Инглиш улсын харьяат Бидерман ба Роберт Смит хэмээх пүүсүүд өөрийн улсын туг далбааг хийсгэсээр байх нь улсын ёсонд үл нийлэлцэхийг эрхлэх газраас гүйцэтгэн шийтгэмой хэмээсэн, үүнд энэ мэт гадаадын харьяат пүүс нар өөр өөрийн улсын далбааг хэрэглэхэд үл болох газар үгүй боловч гагцхүү манай улс лугаа нийтийн дүрмийн ёсоор харилцаа үгүй болох учир хэрхэхийг тогтмуй хэмээн 303 тоот хуудас хүргэж ирсэн хэргийг хэлэлцээд тус улсын дотор суугаа гадаад улсын элчин ба төлөөлөгчдөөс бусад нийтийн журмын ёсоор харилцаа тогтоогоогүй гадаад улсын харьяат пүүс буюу хүмүүст тэдний улсын туг далбааг хэрэглэхгүй байваас зохих явдлыг хойш явуулан гүйцэтгүүлэхээр болов³..." гэсэн байна.

Бас нэгэн сонирхол татахуйц баримт гэвэл F.A. Larson & Company-ийн төлөөлөгчийн 1924 оны 5 сарын 5-нд Гадаад явдлын яаманд ирүүлсэн нэгэн бичигт "... мэдүүлэх учир, үүний урьд тус пүүсээс шанхай хэмээх морь 650-ыг хязгаар нэвтрүүлэх зөвшөөрөл олгохыг гүйн мэдүүлсэн болох нь. Энэ зүйлийн морьдыг чухам Шанхай, Тэншэнь зэрэг уралдааны газар хүргэж худалдахаас бус хятад цэргийн уналга дор оруулах зэрэг харштай газар магад худалдахгүй явдлыг батлан мэдүүлэхээс гадна, хэрэв хойчийн өдөр гэм учир гарах аваас ял үүрэхийг тус пүүс хүлээх явдлыг хамтаар гаргаж үүний тул өргөв⁴" гэжээ. Энэ нь мэдээж хэрэг тухайн үеийн улс төрийн байдалд тааруулан Засгийн газраас тодорхой зарим нэгэн шаардлага тавьж, ам өчгийг нь авдаг байсантай холбоотой бизээ. Мөн түүнчлэн British Far-Oriental Trading

компаний Манжуур дахь салбараас 1923 онд ирүүлсэн нэгэн бичигт “...Сэцэн хан аймгийн хошуудаас үхэр 1000, хонь 5000-ыг худалдан авч Манжуур буюу Хайлаар хотын газар аваачин тоннилгоод махыг нь гадаадад нэвтрүүлэн аваачих тул урьдын удаагаар зөвшөөрч үнэмлэх бичиг олгох ажаамуу⁵” гэсэн байх ажээ.

АНУ-ын дэд ерөнхийлөгч Уэльсээс хойш анх удаа Монголд ирсэн барууны хамгийн томоохон төлөөлөгч гэвэл нь 1954 онд Британий К.Р.Эттли тэргүүтэй 7 хүн байсан бололтой бөгөөд, тэдний Москвагаас Бээжин орох замдаа Улаанбаатар хотын Буянт-Ухаагийн нисэх онгоцны буудалд түр буудаллан өнгөрсөн айлчлал, тэдгээрт үйлчилсэн хүмүүсийн тэмдэглэл зэрэг материал, гэрэл зургийн хамт байдаг ажээ.

Тус хөмрөгийн баримтад өөр нэг нэлээд сонирхол татахуйц захидал байна. Уг захидалд дурьдснаар Монгол улсыг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг Лордын танхимд хэлэлцсэн ярианы тэмдэглэлийг оруулсан байна.

“Британий Лордын танхимд гарсан асуулт

Лорд Виконт Фүнэст-ийн асуулт

- Эрхэм Лордоо, Нэгдсэн вант улсын засгийн газар нь БНМАУ-тай харилцаа тогтоох бодлогыг явуулж байна уу?

Парламентийн Гадаад хэргийн төрийн нарийн бичгийн дарга нарын газраас хариулсан нь

- Хэрэв тэр улс өөрөө хүсвэл Их Британий Засгийн газар нь Монголыг зөвшөөрөн хүлээхээс татгалзахгүй ба НҮБ нь БНМАУ-ыг гишүүнээр элсүүлэхэд ч болох⁶ юм гэж хариулж байсан байна.

Харилцаа тогтоохоос өмнө ирж байсан томоохон хүмүүсийн тоонд 1958 оны 9 сард БНМАУ-ын Энх тайвны хороо, ШУДБХ-ны шугамаар Британий хатан хааны Төв Азийг судлах нийгэмлэгийн хүндэт ерөнхий нарийн бичгийн дарга ноён Смолвуд, Лондон хотын Их сургуулийн Дорно дахин судлалын тэнхимийн монголч эрдэмтэн, доктор Ч.Баудэн нарыг нэрлэж болох ажээ⁷. Энд нэг зүйлийг сонирхуулж хэлэхэд Смолвуд нь 40 жилийн өмнө буюу 1917 онд Монгол оронд ирж байсан байна.

Харилцаа тогтоохоос өмнө ч, хойно ч гэсэн жил бүр олон тооны сэтгүүлч, сурвалжлагч болон судлаачид Монгол оронд ирж үзэх, шинэ Монгол улсын амьдрал ахуйтай танилцах, нүүдэлчин уламжлал, зан заншлыг үзэх хүсэлтэйгээ илэрхийлэн манай элчин сайдын яам болон Гадаад явдлын яаманд албан бичиг, захидал ирүүлдэг байжээ.

Британий ерөнхий сайд агсан, дэлхийн нэртэй улс төрчдийн нэг Уинстон Черчилийг оршуулах ёслолд манай улсаас 1 хүн төлөөлөгчөөр оролцуулахыг хүсэхэд тухайн үеийн манай дотоод нөхцөл байдлын боломжгүйгээс хүнээ явуулж чадаагүй бөгөөд энэ талаар “New York Times” сонины 1965 оны 1 сарын 29-ний дугаарт “Черчиллийг

оршуулах ёслолд дэлхийн 162 орноос төлөөлөгч уригдсан бөгөөд Улаан Хятад, БНМАУ хоёр л татгалзав⁸” гэж бичсэн байна.

Сүүлийн хэдэн жилд зудын гамшгийн үеэр гадны болон олон улсын байгууллагын зүгээс олон янзын хүмүүнлэгийн тусламж дэмжлэг үзүүлж байсан билээ. Британий Засгийн газраас ч гэсэн энэхүү үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байсныг бид бүхэн мэднэ. Тэгвэл одоогоос 40-өөд жилийн өмнө манай талд 116 мянган төгрөгийн үнэ бүхий эм бэлдмэлийг хүмүүнлэгийн тусламж үзүүлэх саналаа ирүүлж⁹ байсныг МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1966 оны 7 сарын дугаар тогтоолд “Улаанбаатарын орчимд үер болсонтой холбогдуулан Британий Засгийн газраас эмийн зүйлээр туслах гэснийг харгалзан уг тусламжийг хүлээн авахыг зөвшөөрсүгэй¹⁰” гэжээ.

Манай хоёр орны соёлын харилцаа анх Монголын энх тайван найрамдлын хорооны гүйцэтгэх хороо, Британий Зөвлөлийн хооронд тохиролцсон 1-2 жилийн төлөвлөгөөний үндсэн дээр явагддаг байсныг манай талын санаачилгаар 1973 оноос хоёр орны гадаад хэргийн яамдын хэмжээнд хэлэлцэн гарын үсэг зурдаг болжээ¹¹. 1969-1990 оны хооронд Британий Лийдсийн Их сургуульд манай төр захиргааны байгууллагын нийт 94 хүн тус бүр 6 сарын хугацаатай англи хэлний мэргэжил дээшлүүлэх курст суралцаж байв. Тэдгээрийн дотор өнөөгийн Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр багтаж, амжилттай суралцан төгсчээ.

1970-1983 онд Британий аль нэгэн хотод жилд нэг удаа Монголыг сурталчлах гэрэл зураг, уран зураг, шуудангийн марк, хүүхдийн гар зургийн үзэсгэлэн тогтмол болдог байв. 1972 онд Лондонгийн Үндэсний кино театр-д монголын уран сайхны “Хүргэн хүү” болон “Миний Монгол” баримтат киног үзүүлж байжээ.¹² Мөн дэлхий дээрх Монголын тухай байнгын үзмэртэй цөөхөн музейн нэг нь Лондон хотын “Хорниман” музей юм.

Монгол Улсыг Британид болон дэлхий дахинд сурталчлахад Британий зүгээс албан болон албан бус байдлаар зарим нэгэн ажил хийгдэж байсныг тэмдэглэх хэрэгтэй болов уу. 1936 оны 1 сарын 31-ний өдөр Гадаад яамны нэр дээр Британий тогтмол сэтгүүлийн нэг “Asian Annual”-ын редакторын Монголын талаар материал хүссэн¹³ захидал ирж байжээ.

Түүнээс бүр хойно 1990 онд Монголын талаар урьд өмнө нь англи хэл дээр гарч байгаагүй, өргөн салбарыг хамарсан томоохон мэдээллийн сан бүхий “Information Mongolia” номыг Британий тал хэвлэн гаргасан ба нээлтийн ёслолын үйл ажиллагаан дээр нь хэвлэлийн үйлдвэрийн эзэн, алдарт тэрбумтан Максвели өөрийн биеэр хүрэлцэн ирж манай элчин сайд болон ШУА-ийн ерөнхийлөгч Н.Содном нарт дээжээс нь

гардуулж байжээ¹⁴. ШУА-ийн Ерөнхийлөгч асан Б.Ширэндэвийг Лийдсийн Их сургуулийн хүндэт доктор¹⁵ болгосон нь монголын эрдэмтэдээс анх барууны Их сургуулийн хүндтэй цол авсан тохиолдол юм. Мөн Дорно дахины судлалын хүрээлэнгийн захирал доктор Н.Ишжамц 1986 онд 1 сарын хугацаатай уригдан ажиллаж байв. Соёлын төлөвлөгөөний дагуу эрдэм шинжилгээний салбарт хийж байсан нэгэн томоохон ажлын нэг жишээ нь 1973 онд ШУА-ийн МАА-н хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Цэдэндорж шилмэл үүлдрийн бухны 1200 тун гүн хөлдөөсөн үр авчран Баруун хараа, Алтанбулагын сангийн аж ахуй, Төв аймгийн Баяндэлгэр суманд 300 гаруй үнэнд хээлтүүлэг хийж байжээ.¹⁶

1963 онд Британий монгол судлаачдыг нэгтгэсэн Англи-Монголын нийгэмлэгийг Кембрижийн Их сургуулийн дэргэд байгуулж¹⁷ байсан байна. Бид бүхний сайн мэдэх Оуэн Латтимор, Айвэр Монгапо, Чарльз Баудэн, Карклайн Хэмфри, Онон Өргөнгөө, Алан Сандрес, Уильям Батлер, Уильям Никсон, Андреа Никсон зэрэг олон тооны Британий монгол судлаачид манай хоёр орны харилцаа хөгжих, ард түмнүүд бие биенээ ойлгон мэдэхэд зохих үүргээ гүйцэтгэсэн билээ. Энэ талаар дараа дараагийн өгүүлэлдээ дэлгэрэнгүй өгүүлэх болно. Британий тогтмол хэвлэл болон судалгааны чанартай сэтгүүлд Монголын тухай өгүүлэл мэр сэр гарахаас гадна Айвор Монтегьюгийн “Цэнхэр огторгуйн орон”, Ж.Ольдриж “Гайхамшигт монгол морь” зэрэг уран зохиолын ном зохиол англи болон бусад хэл дээр хэвлэгдэн уншигч олон түмний хүртээл болжээ.

МОНЦАМЭ-тэй ярилцан тохиролцсоны дагуу Британий “Гранада” компани 1975 онд Монголын тухай баримтат кино хийсний хөлсөнд манай талд 2000 фунт стерлинг төлөөд, мөн 2 хувийг үнэгүй бэлэглэсэн юм. Уг кино нь “Тал дахь хот”, “Говийн захад”¹⁸ гэсэн 2 бүлэгтэй бөгөөд кино багийнхан Говь-Алтай аймгийн Бигэр сумын захиргаанд сумынх нь танилцуулга болох богино хэмжээний киног үнэгүй хийж өгч байжээ.

Урлагийн солилцооны хувьд нэлээд их санаачилга гаргаж байсан бөгөөд анх 1960 онд манай “Учиртай гурван толгой” дуурийг Британид урьж тоглуулахаар ярьж байсан боловч бүтээгүй байна¹⁹. Харин 1986 оны 8-9 сард УАДБЧ-ийн 34 хүнтэй бүрэлдэхүүн Биллингэм, Ланкастерийн 22 дахь удаагийн олон улсын язгуур урлагын дуу бүжгийн фестивалд оролцож давхардсан тоогоор 20 мянга шахам хүнд сонирхуулж олны таашаалыг хүлээж²⁰ байжээ.

Өнөөдөр Улаанбаатар хотын тулгамдсан бэрхшээлийн нэг болоод байгаа агаарын бохирдлын асуудлаар Британий тал нэлээд дээр үеэс санаа тавьж, хамтран ажиллахыг санал болгож байсан байх юм. Бүр

1978 оны 2 сард Британий нүүрсний үйлдвэрийн яамны эрдэм шинжилгээний ажилтан Р.Х.Григори 10 хоногийн хугацаатай Улаанбаатарт томилолтоор ажиллаж байжээ²¹. Тэрээр тухайн үеийн Түлш эрчим хүчний яам, Ус цаг уурын албыг удирдах ерөнхий газар, Улаанбаатар хотын АДХГЗ, Эрүүлийг Хамгаалах Яам, Шинжлэх Ухааны Академи зэрэг байгууллагын хүмүүстэй уулзаж Улаанбаатарын агаарын бохирдлыг багасгах талаар санал солилцжээ. Мөн тэрээр ШУТУХ-той хамтарч гэрийн нөхцөлд тохиромжтой утаа идэгч зуухны зураг төслийг хамтран зохиох, хүрэн нүүрсээр утаагүй түлш болон байгалийн хий үйлдвэрлэх боломжийг судлах талаар зөвлөмж боловсруулахаар болж байв. Энэхүү санаачилга яван явсаар, Британий дараа дараагийн элчин сайдын дэмжлэгтэйгээр төслийн хэмжээнд хэрэгжин өнөөдөр тодорхой үр дүнд хүрэх эхлэл тавигдсан байгааг та бид мэдэх билээ.

1964-1999 оны хооронд Британиас Монголд суух 17 элчин сайд ажиллаж байсан бөгөөд тэдгээр сайдууд манай хоёр орны харилцаанд тус бүрдээ зохих хэмжээний нэмэр оруулж байсныг тэмдэглэх хэрэгтэй болов уу. Жишээ нь элчин сайд А.Мори өөрийн мэдлийн сангаас 15 мянга орчим фунтын үнэ бүхий инкубаторыг Улаанбаатар хотын Эх нялхсын эрдэм шинжилгээний хүрээлэнд бэлэглэж байжээ²². Мөн зарим нэгэн сонирхолтой, хөгжилтэй ч гэж хэлж болохуйц баримт бичиг бас байна. 1977 оны 8 сард элчин сайд Д.Ж.Хартланд цэцэг түүхээр Улаанбаатар хотоос гадагш гарч яваад 80-аад км-ын хол газар машин нь эвдрээд засах арга байгаагүй учраас өөр замын машинд дайгдан буцаж ирээд маргааш өглөө нь яамныхаа ажилчдын хамт очиход машин нь тоногдсон байжээ. 2 хоногийн дараа нөгөө машин дээрээ ачааны тэрэг, өргөгч кран авч очоод машинаа авах гэтэл машин нь алга болсон байв²³. Машин байсан газар нь том машины мөр болон брезинтэн бээлий, “Пимонны вафли” гэсэн жигнэмэгийн цаас л үлдсэн байжээ. Энэ талаар ГЯЯ-ны Ёслолын хэлтэст мэдэгдэхэд тухайн үед мөрдөж байсан гадны төлөөлөгчид хотоос гадагш 40 км-ээс хол газар явахгаар бол урьдчилан мэдэгдэж байх журмыг зөрчсөн байна гээд, Төв аймгийн Гүйцэтгэх захиргаанд мэдэгдэж арга хэмжээ авч өгөхийг хүсч байжээ. Мөн 1979 оны 3 сарын 18-нд Британий ЭСЯ-ны УАЗ-469 машин МҮЭТЗ-ийн авто баазын урдах засмал зам дээр Зөвлөлтийн цэргийн цуваагаар явж байсан Урал-375 маркын машинтай мөргөлдөж ДК-ын машинд эвдрэл учирч, цэргийн цуваа сааталд орсонд²⁴ манай зүгээс “Гудамж, замын хөдөлгөөний дүрэм”-ийн холбогдох заалтыг баримтлаагүйгээс болсон гэж дүгнэж байсан байх юм.

Энд дурьдахад сонин байх болов уу гэсэн өөр нэг баримт нь Лийдсийн Их сургуулийн хятад хэл судлалын тэнхимийн Монголын салбарт монгол хэл үзэж байсан оюутан Ж.Гиббенс соёлын солилцооны

шугамаар 1973 онд МУИС-д ирж 4 сар дадлага хийж байх хугацаандаа Алтанчимэг гэдэг монгол бүсгүйтэй ойр дотно болон гэр бүл болох хүсэлтэй байгаад зөвшөөрөл авч чадалгүй байсаар манай улсаас буцсаны дараа Алтанцэцэгтэй гэрлэх талаарх хүсэлтээ манай элчин сайдын яам болон ГЯЯ-нд олон удаа тавьж байжээ²⁵.

Энэ мэтчилэн сонирхолтой олон тооны баримт судлаачаа хүлээж байгааг хэлэх нь зүйтэй болов уу.

Элчин сайдын яамныхны олж цуглуулсан 1985 оноос өмнө Британид болон бусад газар англи хэлээр хэвлэгдсэн Монголын холбогдолтой зарим номын жагсаалтыг сонирхууль.

J.Bisch "Mongolia Unknown land" London, Alien and Unwin, 1963

H.Haslund. "Tents in Mongolia" London, 1935

S.Jagchid and P.Hyer. "Mongolia's Culture and Society" Folkestone, Vm Dawaon and Sons Ltd, 1979

L.Jisl "Mongolian Journey". London, Batchvorth Press, 1960

"Mongolian Journey", Routledge and Kegan Paul, 1949

John R.Krueger. "Materials for an Oirat-Mongolian to English. Citation Dictionary". 3 vols. Bloomington, Indiana University, The Mongolian Society Inc, 1985

O.Lattimore. "Mongol Journeys" Gape, 1941

Ferdinand D.Lessing. "Mongolian-English Dictionary". Bloomington Indiana University, The Mongolian Society Inc, 1982 (reprint)

I.Montagu "Land of Blue Sky" London, Dennis Dobson, 1956

R.A.Rupen. "How Mongolia is Really Ruled". Stanford University, Calif, Hoover Institution Press, 1971

A.J.K.Sanders. "The Mongolian People's Republic : A General Reference Guide". London, Oxford University Press, 1968

C.R.Bawden, "The Modern History of Mongolia". London, Veidenfeld and Nicolson, and New York, Praeger, 1968

J.A.Boyle. "The Mongol World Empire - 1206-1370". London Variorum Reprints, 1977

W.A.Brown and Onon Urgungu. "History of the Mongolian People's Republic". Cambridge, Mass, Harvard University Press, 1976 English' trails., with extensive footnotes of Vol. III of Mongolia's official history.

I.de Hachewiltz. "Papal Envoys to the Great Khans". London Paber and Faber, 1971

E.E.Ewing. "Between the hammer and the Anvil? Chinese and Russian Policies in Outer Mongolia 1911-1921". Bloomington, Indiana University, 1980

W.A.Heissig. "Lost Civilization". London, Thames and Hudson, 1964

O.Lattimore. "Nomads and Commissars". London, Oxford University Press, 1962

O.Lattimore. "Nationalism and Revolution in Mongolia". Leiden, E.J.Brill, 1955. English trans. of the official life of the revolutionary leader Suhbaatar, with introduction.

O.Lattimore. "Studies in Frontier History, Collected Papers 1929-1958". London, Oxford University Press, 1962

S.Murphy, "Soviet Mongolia". University of California, 1966

Onon Urgungu. (Trans.) "Mongolian Heroes of the 20th Century" New York, AMS Press, 1976

R.A.Rupen. "Mongols of the Twentieth Century". Vol.1 (History), fol.2 (Bibliography) The Hague, Indiana University and Mouton and Co.

R.A.Rupen. "The Mongolian People's Republic". Stanford, Calif, Hoover Institution Studies, 1966

J.J.Sanders, "The History of the Mongol Conquests". London, Routledge and Kegan Paul, 1971

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-1,
2. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-1, 3-р нугалбар бичиг
3. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-1, 16-р нугалбар бичиг
4. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-1, 9-р нугалбар бичиг
5. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-1, 5-р нугалбар бичиг
6. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-4, 27-р хуудас
7. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-6, 22-р хуудас
8. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-18, 22-р хуудас
9. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-200, 17-р хуудас
10. МАХН-ын архив, ф-4, данс-30, хн-6, 239-р хуудас
11. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-200, 53-р хуудас
12. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-200, 89-р хуудас
13. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-2, 15-р хуудас
14. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-189, 134-р хуудас
15. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-87, 37-р хуудас
16. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-89, 176-р хуудас
17. Journal of the Anglo-Mongolian Society, Cambridge, 1983
18. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-200, 251-р хуудас
19. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-6, 78-р хуудас
20. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-136, 17-р хуудас
21. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-200, 132-р хуудас
22. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-200, 153-р хуудас
23. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-200, 205-р хуудас
24. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-200, 205-р хуудас
25. ГХЯ-ны ГХТА ф-28, данс-1, хн-200, 95-р хуудас